

Компанийн тухай

Ард Даатгал ХК нь 1994 онд үүсгэн байгуулагдаж, холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд заасан шаардлагуудыг ханган Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2/16 тоот даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авч, 30 гаруй жил үйл ажиллагаа явуулж буй хувьцаат компани юм.

2018 онд IPO гарган 9,500 орчим хувьцаа эзэмшигчтэй Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй нээлттэй хувьцаат компани болсон.

Өдгөө Монгол Улсын даатгалын салбарт тэргүүлэгч байр суурь бүхий олон улсад болон дотоодод нэр хүндтэй тогтвортой даатгалын үйлчилгээ үзүүлэгч болсон төдийгүй баялаг бүтээгчдийн найдвартай ар тал болон дэмжиж ажилласаар ирсэн нь улсынхаа эдийн засаг, нийгмийн хөгжилд тодорхой хувь нэмрээ оруулан амжилттай ажиллаж байгааг харуулж байна.

Хувьцаа эзэмшигчид (2024.12.31)

56.7%



Ард Санхүүгийн Нэгдэл ХК*

43.3%



Иргэд, аж ахуйн нэгж

* Ард санхүүгийн нэгдлийн хамаарал бүхий компаниуд

Хувьцааны тоо ширхэг

25 сая

Хувьцааны мэдээлэл

MSE: AIC (www.mse.mn)



Тоон үзүүлэлт

1

Хувьцаа эзэмшигчдийн тоогоор

+70

Хамтран ажилладаг зуучлагч

+30

Үйл ажиллагаа явуулсан жил

19 тэрбум ₮

Олгосон нөхөн төлбөр

+100

Нийт ажилтны тоо

9.5k

Хувьцаа эзэмшигч

+50

Даатгалын бүтээгдэхүүн

45 тэрбум ₮

Хураамжийн орлого

5

Хамтран ажилладаг банк

9%

Зах зээлд эзлэх хувь


21

Салбарын тоо

256k

Даатгуулагчийн тоо

Түүхэн замнал



Даатгалын үйлчилгээ

Ард Даатгал ХК нь ердийн даатгалын компани бөгөөд албан журмын даатгалаас гадна сайн дурын 50 гаруй төрлийн даатгалын үйлчилгээг харилцагчдадаа санал болгож байна. Бид жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, малын индексжүүлсэн даатгал, газар тариалангийн даатгал, баталгааны даатгалыг анхлан хэрэгжүүлэгчдийн нэг билээ.



Давхар даатгал


Ард Даатгал компани 2003 оноос хойш Англи, Америк, Герман, Япон, Сингапур, Швейцар зэрэг олон улсын өндөр үнэлгээ бүхий давхар даатгалын томоохон компаниудад тогтмол даатгуулж ирсэн туршлагатай билээ.

Бид ХБНГУ-ын Аллианц компанитай стратегийн түншлэлийн хүрээнд урт хугацааны туршид хамтран ажиллаж байна. Мөн Ханновер Ри, Монголиан Ри, Свисс Ри зэрэг компаниуд нь манай байнгын хамтран ажилладаг давхар даатгагч бөгөөд бид өөрсдийн эрсдэлийн багцыг факультатив болон трити гэрээ байгуулан давхар даатгуулдаг.

ХУРААМЖ	2023	%	2024	%
Факультатив	1,528	27%	3,163	44%
Фронтинг	3,339	59%	3,150	44%
Трити	792	14%	838	12%
Нийт	5,660	100%	7,150	100%

(Даатгалын гэрээгээр)

Давхар даатгалын хураамж (сая төгрөг)




НӨХӨН ТӨЛБӨР	2023	%	2024	%
ЭМГОД*	196	5%	87	9%
Хөрөнгө	729	19%	258	28%
МИД**	320	8%	586	63%
Санхүү	2,559	67%		
Нийт	3,804	100%	931	100%

*Эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгал

**Малын индексжүүлсэн даатгал

Баталгааны даатгал

Ард Даатгал компани нь Даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсны дагуу даатгагчийн баталгааг үзүүлж эхэлсэн.



Эрүүл мэндийн даатгал

Бид **Ард-Мэнд** дотоодын эрүүл мэндийн даатгал, **Ard-Medicare (Ard-Med)** олон улсын эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүнийг санал болгон **150 мянга** гаруй харилцагчдад эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалын үйлчилгээ үзүүлж, харилцагчдын тоо өсөн нэмэгдлээ.

Ard-Medicare олон улсын эрүүл мэндийн даатгал нь дэлхийн 200 гаруй оронд 330 мянга гаруй гэрээт эмнэлгүүдээр үйлчлүүлэх өргөн сүлжээ бүхий олон улсын **MSH China** эрүүл мэндийн үйлчилгээний байгууллагатай хамтран ажиллаж, хэрэгжүүлдэг бүтээгдэхүүн юм.

Манай харилцагчдын хувьд олон улсын эрүүл мэндийн даатгалын шууд төлбөрийн (direct billing) үйлчилгээг Азийн улсууд болох БНХАУ, Солонгос, Япон, Тайланд, Монгол болон Австрали, Герман, Швед, Швейцар зэрэг дэлхийн улс орнууд дахь сүлжээ эмнэлгүүдээр үйлчлүүлж авсан байна.



Санхүүгийн үзүүлэлт (сая төгрөг)

	Хураамж	Нөхөн төлбөр	Давхар Даатгал	Нийт хөрөнгө	Нөөц сан	Цэвэр ашиг
2022	22,315	7,858	4,231	35,645	14,704	737
2023	32,438	14,095	5,660	44,156	22,367	3,277
2024	45,244	19,663	7,150	51,133	26,912	2,410

Харьцаа үзүүлэлт

	Хохирлын харьцаа*	Зардлын харьцаа**	Хосолсон харьцаа
2022	40%	59%	99%
2023	41%	56%	97%
2024	49%	49%	98%

*Цэвэр нөхөн төлбөр / Орлогод тооцсон хураамж
**Үйл ажиллагааны зардал / Орлогод тооцсон хураамж

Даатгалын багц мэдээлэл (сая төгрөг)

Даатгалын хэлбэр	Хураамж			Нөхөн төлбөр		
	2023	2024	Өөрчлөлт	2023	2024	Өөрчлөлт
Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	5,217	5,320	▲ 2%	2,197	2,440	▲ 11%
Хөрөнгийн даатгал	5,557	6,487	▲ 17%	1,103	497	▼ -55%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	6,982	12,062	▲ 73%	2,608	3,860	▲ 48%
Ачааны даатгал	348	427	▲ 23%	36	67	▲ 84%
Барилга угсралтын даатгал	552	2,303	▲ 317%	-	-	-
Хариуцлагын даатгал	2,064	4,372	▲ 112%	80	279	▲ 247%
Жолоочийн албан журмын даатгал	7,957	11,874	▲ 49%	4,157	9,366	▲ 125%
Бусад (8 хэлбэр)	3,762	2,399	▼ -36%	3,914	3,153	▼ -19%
Нийт	32,438	45,244	▲ 39%	14,095	19,663	▲ 39%

Ердийн даатгалын зах зээл 2024 онд (сая төгрөг)

Даатгагчийн тоо: 17	Зах зээл	Зах зээлийн дундаж	Ард Даатгал
Даатгалын нийт хураамж	498,328	31,146	▲ 45,244
Давхар даатгалын хураамж	165,337	9,726	▲ 7,150
Даатгалын цэвэр хураамж	318,292	19,893	▲ 36,800
Орлогод тооцсон хураамж	280,830	16,519	▲ 33,610
Нийт нөхөн төлбөр	158,326	9,895	▲ 19,663
Цэвэр нөхөн төлбөр	123,513	7,720	▲ 16,338
Үйл ажиллагааны зардал	168,052	9,885	▲ 16,311
Нийт хөрөнгийн дүн	582,346	34,256	▲ 51,133
Нөхөн төлбөрийн нөөц сангийн дүн	78,078	4,593	▲ 6,102
Эздийн өмчийн дүн	225,485	13,264	▲ 19,595
Хохирлын харьцаа*	56%	-	59%
Зардлын харьцаа*	60%	-	49%
Хосолсон харьцаа*	116%	-	108%

*СЗХ-ны 2024 оны даатгалын салбарын үйл ажиллагааны нэгдсэн тайлан

Нөхөн төлбөрийн үйлчилгээ

2024 онд малын индексжүүлсэн даатгалаар нийт **696.8 сая** төгрөгийн нөхөн төлбөр олгосон. Худалдаа Хөгжлийн Банктай байгуулсан цалингийн зээлийн даатгалаар нийт **261** даатгуулагчид **2.4** тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон. Ард Даатгал ХК нь даатгалын гэрээний дагуу даатгалын нөхөн төлбөр олголтоор салбартаа тэргүүлдэг.


НӨХӨН ТӨЛБӨРИЙН ТОО	2023	Хувь	2024	Хувь
Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	2,899	33%	2,193	17%
Хөрөнгийн даатгал	158	2%	215	2%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	1,620	18%	2,470	19%
Зээлийн даатгал	253	3%	266	2%
Хариуцлагын даатгал	56	1%	61	0%
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	3,804	43%	7,782	60%
Бусад	32	0%	10	0%
Нийт	8,822	100%	12,997	100%
Өдөрт шийдвэрлэсэн нөхөн төлбөрийн тоо	34		50	

Онцлох үйл явдал

- 2024 онд даатгалын салбар үүсэж хөгжсөний 90 жил, Ард даатгал компанийн үүсгэн байгуулагдсаны 30 жилийн ой болж ажилтнууд болон харилцагч нарт чиглэсэн олон талт ажлыг зохион байгуулсан.
- Даатгалын салбарт анх удаа **"Тогтвортой хөгжлийн тайлан 2023"** тайланг гаргаж, даатгалын зах зээлийн бусад оролцогч нарт энэхүү тайланг гаргахыг уриалсан үйл ажиллагааг зохион байгуулсан.
- Даатгалын нөхөн төлбөрийн хүсэлт илгээх болон даатгалын гэрээ цуцлах хүсэлтийг цахимаар хүлээн авч, шийдвэрлэдэг болов.
- Мессеж үйлчилгээгээр жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээг онлайнгаар сунгах үйлчилгээг эхлүүлэн хэрэгжүүлж байна.
- Баталгааны даатгал, ногоон даатгалын үйлчилгээг зах зээлд шинээр нэвтрүүлсэн.

Сонирхолтой судалгаа

- Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйлчилгээ үзүүлэгч 16 даатгалын компани байдаг бөгөөд 2024 оны жилийн эцсийн тайлангийн байдлыг графикаас харж болно.
- 2024 онд тээврийн хэрэгслийн даатгал болон жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нийт 10,252 даатгалын тохиолдлын 13.2 тэрбум төгрөгийн хохирлыг шийдвэрлэсэн нь Компанийн нийт нөхөн төлбөрийн 67%-ийг эзэлж байна
- Дээрх даатгалын тохиолдлын 90 орчим хувь нь "зам тээврийн хөдөлгөөнд оролцох үеийн мөргөлдөх, шүргэлдэх, онхолдох зэрэг эрсдэл" байх бөгөөд нийт тохиолдлын 71% нь жолоочийн даатгал, 29% нь тээврийн хэрэгслийн даатгалаар даатгагдсан байна.
- Ард Даатгал ХК ажлын өдөр бүр 30 даатгуулагчид 36.0 орчим сая төгрөгийн нөхөн төлбөрийг зөвхөн жолоочийн хариуцлагын албан журмын даатгалаар олгож байна гэсэн тооцоо гарчээ.
- Нийт хохирлын 50 хувийг тус компанийн хохирол баталгаажуулалтаар, 50 хувийг ТЦГ-ын ослын баталгаажуулалтаар тус тус шийдвэрлэсэн байна.
- Жолоочийн даатгал болон тээврийн хэрэгслийн даатгалын дундаж нөхөн төлбөрийн хэмжээг өмнөх онтой харьцуулбал:



Даатгалын хэлбэр	Нөхөн төлбөрийн хэмжээ (сая ₮)		Нөхөн төлбөрийн тоо		Дундаж нөхөн төлбөр (сая ₮)	
	2023	2024	2023	2024	2023	2024
Жолоочийн даатгал	4,156.6	9,365.7	3,804	7,782	1.1	1.6
Тээврийн хэрэгслийн даатгал	2,607.9	3,680.7	1,620	2,470	1.6	1.2
Нийт	6,764.5	13,226.3	5,424	10,252		

